



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН САЙДЫН ТУШААЛ

2026 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/95

Улаанбаатар хот

Хяналтын хуудас батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх заалт, Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 479 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хяналт шалгалт хийх нийтлэг журам”-ын 15.3, 16.1, 16.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Боловсролын салбарын хяналт шалгалтын үйл ажиллагаанд хэрэглэх 03/6.1-1 кодтой “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас”-ыг нэгдүгээр, 03/6.1-2 кодтой “Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас”-ыг хоёрдугаар, 03/6.1-3 кодтой “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас”-ыг гуравдугаар, 03/6.1-4 кодтой “Дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас”-ыг дөрөвдүгээр, 03/6.1-5 кодтой “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын дотуур байрын үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас”-ыг тавдугаар, 03/6.1-6 кодтой “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын дотуур байрын үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас”-ыг зургаадугаар хавсралтаар шинэчилж, 03/6.1-7 кодтой “Дээд боловсролын сургалтын байгууллагын дотуур байрын үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас”-ыг долоодугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэхүү тушаалын хавсралтаар баталсан хяналтын хуудсыг хяналт шалгалтын үйл ажиллагаанд ашиглахад боловсролын хяналт шалгалтын чиг үүрэг хэрэгжүүлж байгаа байцаагч нарыг арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Л.Төгсбаяр/-т үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаалыг баталсантай холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны “Хяналтын хуудас шинэчлэн батлах тухай” А/150 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



П.НАРАНБАЯР

1420010307